



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/729

Булган сум

**"Авлигын эсрэг нэгдье" нэгдсэн арга хэмжээг  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны II/03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/633 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд "Авлигын эсрэг нэгдье" нэгдсэн арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 8,200,000 (найман сая хоёр зуун мянга) төгрөгийг "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Уг арга хэмжээг зохион байгуулахад удирдлага зохион байгуулалтаар хангаж, тайланг зохих журмын дагуу гаргаж, санхүүтэй тооцоо хийхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

